

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

ГАРЧИГ

ХЭСЭГ 1 – ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Бүлэг I. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТОӨЗ)

Энэ бүлэг нь тендер бэлтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг тендерт оролцогчдод өгнө. Тендер ирүүлэх, тендер нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээлэл, мөн хамгийн сайн тендерийг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон тендерт оролцогч тухайн гэрээг гүйцэтгэх чадвартай эсэхийг тогтоох чадварын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах хамгийн доод шаардлагууд энд бичигдсэн байна. Нэгдүгээр бүлэг дэх зүйл заалтуудыг захиалагч өөрчлөхгүйгээр ашиглах ёстай.

Бүлэг II. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)

Энэ бүлэг нь тухайн худалдан авалт бүрт тохирсон онцлог заалтуудыг агуулах бөгөөд эдгээр заалтууд нь 1 дүгээр бүлгийн холбогдох заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулна.

Бүлэг III. Тендер шалгаруулалтын жишиг маягтууд

Энэ бүлэгт тендер ирүүлэх маягт, үе шатны ажлын хуваарийн хүснэгт, тендерийн баталгааны маягт болон чадварын мэдээлэл ирүүлэх маягт зэрэг тендерт оролцогч бөглөж өөрийн тендерийн хамт ирүүлэх шаардлагатай маягтууд байна.

ХЭСЭГ 2 – АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүлэг IV. Техникийн тодорхойлолт, ажлын зураг болон бусад шаардлага

Энэ бүлэг нь ажил гүйцэтгэх хуваарь, техникийн тодорхойлолт болон тухайн ажлын инженерийн зураг, тайлбар зэрэг мэдээллүүд багтана.

ХЭСЭГ 3 – ГЭРЭЭ

Бүлэг V. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН)

Энэ бүлэг нь захиалагч байгууллага ажил гүйцэтгүүлэх болон түүнийг дагалдах бараа, үйлчилгээ худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан ерөнхий нөхцөл, заалтуудыг агуулна. ГЕН-ийн заалтуудын үг, үсэг, агуулгыг өөрчилж үл болно.

Бүлэг VI. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)

Энэ бүлэгт гэрээний тусгай нөхцөл буюу тухайн худалдан авах барааны онцлогтой холбогдуулан гэрээний ерөнхий нөхцөлд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгана.

Бүлэг VII: Гэрээний маягт

Энэ бүлэгт Гэрээний маягт болон захиалагч шаардсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгогдсоны дараа шалгарсан тендерт оролцгчийн бөглөж ирүүлэх Гүйцэтгэлийн баталгаа, Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтууд багтана.

Хавсралт: Тендерийн Урилга

Тендерийн урилгын маягтыг энэхүү тендерийн баримт бичгийн төгсгөлд хавсралт болгон орууллаа.

Жич: Энэхүү жишиг бичиг баримтын хэсэг, бүлгийн оноосон нэр, гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэгдсэн бөгөөд ямарваа нэгэн хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

[ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР]

[АЖЛЫИН ТОВЧ НЭР] ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТБИЧИГ

Тендер шалгаруулалт
гэрээний нэр, дугаар:

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж

Тендерт оролцогчид Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл, түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг энэ бүлэгт тусгана. Захиалагч тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа ТОӨЗ-г чанд мөрдөнө.

Гүйцэтгэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус 5 дугаар бүлэгт буюу гэрээний ерөнхий нөхцөл болон 6 дугаар бүлэгт буюу гэрээний тусгай нөхцөлд тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь гэрээний хэсэг болохгүй.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

ГАРЧИГ

A. Ерөнхий зүйл

1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Тендерт оролцогчийн чадвар
6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
7. Тендер шалгаруулалтад оролцох зардал
8. Ажлын талбайтай танилцах

Б. Тендерийн баримт бичиг

9. Тендерийн баримт бичгийн агуулга
10. Тендерийн баримт бичгийг тодруулах
11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт
12. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

В. Тендер бэлтгэх

13. Тендерийн хэл
14. Тендерийн иж бүрдэл
15. Тендерийн маягт болон ажлын хуваарь
16. Хувилбарт тендер
17. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
18. Тендерийн болон төлбөрийн валют
19. Техникийн саналын бүрдэл баримт бичиг
20. Тендер хүчинтэй байх хугацаа
21. Тендерийн баталгаа
22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

Г. Тендер ирүүлэх

23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
25. Хугацаа хоцорсон тендер
26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

Д. Тендерийг нээх, үнэлэх

27. Тендерийг нээх
28. Нууцлал
29. Тендерийн тодруулга
30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
31. Алдааг залруулах
32. Нэг валютэд хөрвүүлэх
33. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох.

34. Тендерийг үнэлэх, харьцуулах

Е. Гэрээ байгуулах эрх олгох

35. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
36. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
37. Гэрээнд гарын үсэг зурах
38. Гүйцэтгэлийн баталгаа

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|--|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид “ТШӨХ” гэх)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь ТШӨХ, техникийн тодорхойлолт болон б 6 дугаар бүлэг буюу гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх)-д дурдсан ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна. Ирүүлсэн тендерүүдээс хамгийн сайн тендерийг ТББ-ийн дагуу үнэлж, шалгаруулах ба уг тендерийг ирүүлсэн оролцогчтой ГТН болон ТШӨХ-д дурдсан нэр, дугаар бүхий гэрээг байгуулахаар зохион байгуулж байна.</p> <p>1.2. Шалгарсан тендерт оролцогч ньгэрээгээр гүйцэтгэх ажлыг ТШӨХ болон ГТН-д заасан ажил дуусгах хугацаанд багтаан дуусгана.</p> <p>1.3. Ажил нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | <p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.</p> |
| 3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл | <p>3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон тендерт оролцогч, гүйцэтгэгч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэмжээг сахин биелүүлэх ёстай.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p> |
| 4. Эрх бүхий тендерт оролцогч | <p>4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.</p> <p>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2 Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> |

- 4.2.3 Төрийн өмчтөг болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
 - 4.2.4 Сүүлийн З жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээс ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.5 Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий хуульд заасан эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.6 Сүүлийн З жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиолцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
 - 4.2.7 Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
 - 4.2.8 Тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
 - 4.2.9 Тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3. Тендерт оролцогч 4.2.1-4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, эсвэл үүсгэн байгуулагдсан улсын түүнтэй адилтгах бусад баримт бичиг;
 - (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;
 - (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл;

(г) Шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр. Тендерт оролцогчийн хувьд ТОӨЗ-ны 4.2.2, 4.2.4, 4.2.5 болон 4.2.6 –д дурдсан нөхцөл байдал үүсч байсан бол энэ тухайг захиалагчид мэдэгдэж холбогдох шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг тендерийн хамт ирүүлэх үүрэгтэй.

**5. Тендерт
оролцогчийн
гэрээг
хэрэгжүүлэх
чадвар**

- 5.1. Бүх тендерт оролцогч нь 3 дугаар бүлэгт заасан “Тендерийн маягт, чадварын мэдээлэл, зөвшөөрлийн бичиг” –ын дагуу мэдээлэл ирүүлэх, ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлал болон хуваарь, шаардлагатай бол зураг, ажлын графикийн хамт ирүүлэх ёстой.
- 5.2. Хэрэв захиалагч урьдчилсан сонголт явуулаагүй бөгөөд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол бүх тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварыг тогтоохтой холбогдуулан захиалагчийн шаардсан дараах мэдээллийг нотлох баримт болгон тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн дагуу хийгдэх ажлын тухайд уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;
 - (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан жилийн санхүүгийн тайлан. Хэрэв ТШӨХ-д тусгайлан заасан бол санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байна;
 - (в) гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчиний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
 - (г) ТШӨХ-д заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт;
 - (д) тухайн тендерт оролцогч ТШӨХ-д заасан хугацаанд төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг жил жилээр харуулсан мэдээлэл, одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээр гэрээний талаар лавлах мэдээлэл авч болох үйлчлүүлэгч, захиалагчийн хаяг;
 - (е) гэрээг гүйцэтгэхэд ашиглагдах санал болгож буй үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл (зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмын жагсаах);
 - (ё) гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлох баримт бичиг (үүнд зээл авах баталгаажсан эрх болон боломжтой санхүүгийн бусад эх үүсвэр);
 - (ж) захиалагч харилцагч банкнаас нь тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл;

- (3) одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
- (и) ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүнийг түншлэл гэж үзэж, түншлэгч компанийн талаарх мэдээллийг мөн ирүүлнэ. Туслан гүйцэтгүүлэх ажлын талаарх мэдээллийг тендерийн саналд тусгаж ирүүлнэ. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох ажлын нийт өртөгийн дээд хязгаарыг ТШӨХ-д тодорхойлно.

5.3. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан ажлыг гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үүнд:

- (а) ТШӨХ-д заасан хугацааны аль нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан мөнгөн дүнгээс багагүй байх;
- (б) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг удаагийн ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага (энэ шаардлагыг хангахын тулд нэрлэсэн ажлын доод тал нь 70 хувийг нь гүйцэтгэсэн байх шаардлагатай);
- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь олж (өөрийн, түрээслэх/гэрээ шаардах/, авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) гэрээнд заасан ажилтай төрөл, дүнгээрээ дүйцэх ажил дээр ТШӨХ-д зааснаас доошгүй хугацаанд нь гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий ерөнхий инженертэй байх;
- (д) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- (е) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

5.4. Тендерт оролцогч түншлэлийн хувьд 5.3 (а) ба (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 5.3 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх ёстой.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана.

	<p>Түншлэл 5.3(б), (в), (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоходоо түншлэлийн гишүүн тус бүрийн нөөц бололцоог хамтад нь харгалзан үзнэ.</p> <p>Түншлэлийн гишүүн тус бүр 5.3(е)-г хангасан байх ёстой.</p>
	<p>5.5. Тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалзаж үзэхгүй. Харин туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ажилд тусгай зөвшөөрөл шаардагдах бол туслан гүйцэтгэгч уг шаардлагыг хангасан байвал зохино.</p> <p>5.6. Тендерт оролцогч тендерийн үнэлгээнд 7.5 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол тендерт оролцогч нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг хангаж байгаа гэдгийг нотлон ирүүлэх шаардлагатай.</p>
6. Тендерт оролцогч түншлэл	<p>6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл” гэх, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер шалгаруулалтад оролцох тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> (а) түншлэлийн гишүүн бүр энэхүү ТӨӨЗ-ны 5.2-т заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ. (б) түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна; (в) ТӨӨЗ-ны 1.1-д заасан хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх; (г) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох; (д) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх; (е) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх. <p>6.2. Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгaaагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.</p>
7. Тендер шалгаруулалтад оролцох зардал	<p>7.1. Тендерт оролцогч тендерийг бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нэхцэлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.</p>
8. Ажлын талбайтай танилцах	<p>8.1. Ажлын талбай, түүний байршил, орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг тендерт оролцогч авч ашиглаж болно.</p>

Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

- 9. Тендерийн баримт бичгийн агуулга**
- 9.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан З хэсэг баримт бичиг болон ТОӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу оруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3. Тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягт
- Тендерийн маягт
 - Чадварын мэдээллийн маягт
 - Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл
 - Гэрээний маягт

II ХЭСЭГ

- Бүлэг 4. Ажлын шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

- Бүлэг 5. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 6. Гэрээний тусгай нөхцөл
Бүлэг 7. Гэрээний маягт
- Гэрээний маягт
 - Гүйцэтгэлийн баталгааны маягт
 - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

- 9.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 9.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх зааварчилгаа, нөхцөл, шаардлагатай маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.
- 10. Тендерийн баримтбичгийг тодруулах**
- 10.1. Тендерт оролцохыг сонирхогч аливаа этгээд нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ.

Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

- 10.2.** Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 12 дугаар зүйл, 20.2 дахь хэсэгт заасныг баримтална.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1.** Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТШӨХ-д заасан бол тендерт оролцохыг сонирхогч этгээд түүний томилсон төлөөлөгч нарыг урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсч болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар тендерт оролцогчдоос тавьж буй асуултанд хариу өгөх зорилготой байна.
- 11.2.** Тендерт оролцохыг сонирхогч өөрийн асуултыг дээрх уулзалтыг зохион байгуулахаас өмнө бичгээр ирүүлж болно.
- 11.3.** Эдгээр асуултын агуулга, түүний талаарх хариуг тусгасан уулзалтын тэмдэглэл болон уулзалтын дараагаар бэлтгэгдсэн бусад хариу зэргийг асуулт тавьсан эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.
- 11.4.** Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 12, 24.2-т заасныг баримтална.
- 11.5.** Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцоогүй шалтгаанаар тендерт оролцохийг сонирхогч этгээдийн тендерт оролцох эрхийг хязгаарлаж болохгүй.
- 12. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 12.1.** Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 12.2.** Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 12.3.** Шаардлагатай бол тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг тендер бэлтгэхдээ авч үзэхэд шаарддагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох үүднээс захиалагч ТӨӨЗ-ны 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 13. Тендерийн хэл**
- 13.1.** Тендер, түүнчлэн тендертэй холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалууд болон бусад баримт материалудыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл

дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвэл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална

- 13.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТШӨХ-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг үндэслэн тендерийн үнэлгээнд харгалзах болно.
- 13.3. Тендерт оролцогч тендерээ Монгол хэл болон ТШӨХ-д заасан гадаад хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.

14. Тендерийн иж бүрдэл

- 14.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) ТОӨЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үе шатны ажлын хуваарь
 - (б) ТОӨЗ-ны 15, 17 дугаар зүйлийн дагуу бэлтгэж ирүүлэх үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Захиалагч ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд ирүүлэхийг шаардсан тендерийн баталгаа;
 - (г) тендерт оролцогчийг төлөөлж ТОӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж бичгээр гаргасан байх, түүний итгэмжлэл;
 - (д) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан нотлох баримтууд;
 - (е) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 5 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
 - (ё) ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэж ирүүлэх техникийн санал;
 - (ё) ТОӨЗ-ны 16дугаар зүйлд захиалагч тусгайлан зөвшөөрсэн тохиолдолд ирүүлэх хувилбарт тендер;
 - (ж) ТОӨЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад буюу ТШӨХ-д шаардсан материал.

15. Тендерийн маягт болон үе шатны ажлын хуваарь

- 15.1. Тендерт оролцогч нь 3 дугаар бүлэг буюу тендерийн жишиг маягтуудаасзохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа

өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичнэ.

- 16. Хувилбарт тендер**
- 16.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
- 17. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**
- 17.1. Тендерийн маягт болон үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарыт тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь дараах шаардлагад нийцсэн байна.
- 17.2. Тендерийн үнэ нь ТОӨЗ-ны 1.1-д тодорхойлсон гэрээт ажлын нийт өртөгийг хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт¹ үндэслэнэ.
- 17.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн² бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ өгнө. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 17.4. Тендерийн маягтад тусласан үнэ нь санал болгож буй аливаа үнийн хөнгөлөлт тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
- 17.5. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусласан байна.
- 17.6. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 17.7. Тухайн тендерийн дагуу гүйцэтгэх ажлыг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТОӨЗ-1.3 дахь хэсгээс лавлана уу. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.
- 17.8. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТОӨЗ-ны 30 дугаар зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч үнэ тохируулахаар заасан тохиолдолд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

¹Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарыт” гэснийг “ажлын тоо хэмжээнд” гэж солино.

²Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн” гэснийг “ажлын тоо хэмжээнд тодорхойлогдсон” гэж солино.

- 17.9. Гэрээний хэрэгжилтийн явцад үнэ тохируулах нөхцөлтэй байхаар заасан бол ажлын гүйцэтгэлийн явцад үе шатны ажлын хуваарьт заасан үнэд³ гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлд заасан нөхцөл, аргачлалын дагуу үнийн тохируулга хийнэ. Тендерт оролцогч гэрээний тусгай нөхцөл болон гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлд заасны дагуу шаардагдах бүх мэдээллийг тендерийн хамт ирүүлнэ.
- 18. Тендерийн болон төлбөрийн валют**
- 19. Техникийн саналийн бүрдэл баримт бичиг**
- 20. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 21. Тендерийн баталгаа**
- 18.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.
- 19.1. Тендерт оролцогч нь ажлын гүйцэтгэл болон хугацааны талаар захиалагчийн шаардлагад нийцэж буйг нарийвчлан харуулсан график, ажлыг гүйцэтгэх арга барил, тоног төхөөрөмж, ажиллах хүчин, ажлын хуваарийн талаарх мэдэгдэл зэргийг агуулсан Техникийн саналыг тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэгт заасан маягтаар бусад мэдээллийн хамтаар бэлтгэж тендерт ирүүлнэ.
- 20.1. Тендер нь захиалагч ТӨӨЗ-ны 27.1-тзаасны дагуу тогтоосон тендер нээх он, сар, өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерт оролцогчоос тендерийн маягтад санал болгож ирүүлсэн тендер хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон дээрх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүний тендерийг үндсэн шаардлага хангагүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.
- 20.2. Онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогчид хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлт гаргах болон түүний хариуг ирүүлэхдээ бичгээр, эсхүл утсан холбоогоор харилцана. Тендерт оролцогч тендерийн баталгааг улсын орлого болгохгүйгээр уг хүсэлтээс татгалзах эрхтэй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчоос тендерийнх нь агуулгыг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхийг хориглоно. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг 21 дүгээр зүйлд нийцүүлэн мөн хугацаагаар сунгана.
- 21.1. Тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.
- 21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.
- 21.4. Тендерийн баталгаа нь Монгол улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа байна. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэгт заасан маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагчийн урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн

³ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарьт заасан үнэд” гэснийг “ажлын тоо хэмжээнд заасан нэгж үнэ болон нийт үнэд” гэж солино.

баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоног байна.

- 21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.
- 21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.7. ТОӨЗ-ны 21.1-д шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерийг захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 21.8. Тендер нь шалгаргаагүй оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор захиалагч хүчингүй болгоно.
- 21.9. Шалгарсан тендерт оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 40 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлэхэд хүчингүй болгоно.
- 21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно:
 - (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
 - (б) тендерт оролцогч ТОӨЗ-ны 31.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөгүй бөгөөд ТОӨЗ-ын 37.2-т заасан нөхцөл үүссэн бол;
 - (в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:
 - 1) ТОӨЗ-ны 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй бол;
 - 2) ТОӨЗ-ны 40 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.
 - (г) тендерт оролцогчийн гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

- 22.1. Тендерт оролцогч 14 дүгээр зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсэн тохиолдолд эх хувийг баримтална.
- 22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийн төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл

танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

- 22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.
- 22.4. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- | | |
|--|---|
| 23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх | <p>23.1. Тендерт оролцогчид өөрийг тендерийг шуудангаар, эсвэл өөрөө буюу өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.</p> <p>23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТОӨЗ-ны 23.3, 23.4-т заасныг баримтлана.</p> <p>23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">(а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;(б) ТШӨХ-д заасан хаягаар ТОӨЗ-ны 1.1-д заасан захиалагчийн нэр дээр хаяглах;(в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаар тодорхой бичсэн байх;(г) ТОӨЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх. <p>23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.</p> <p>23.5. ТОӨЗ-ны 23.1-д зааснаас өөр хэлбэрээр (электрон шуудангаар, эсвэл факсаар г.м) ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасныг үндэслэн хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.</p> |
|--|---|

24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	24.1. Захиалагч тендерийг ТШӨХ-д заасан хаягаар, нээх огноо, цагаас өмнө хүлээн авна. 24.2. Захиалагч ТОӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
25. Хугацаа хоцорсон тендер	25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах	<p>26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.</p> <p>26.2. Тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих эсхүл тендерийг буцааж авах мэдэгдлийг ТОӨЗ-ны 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн нэмэлт бичиглэл хийж ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид ирүүлнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.</p> <p>26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерт аливаа нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно.</p> <p>26.4. ТОӨЗ-ны 26.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүй буцаан олгоно.</p> <p>26.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь ТОӨЗ-ны 21д зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.</p>

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

27. Тендерийг нээх	27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна. 27.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Хэрэв “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн хүсэлтэд гарын үсэг зурсан этгээд нь тендерт оролцогчийг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд болохыг баталсан гарын үсгийн баталгаа, итгэмжлэл дагалдаж ирээгүй бол түүний үндсэн тендерийг буцаахыг зөвшөөрөхгүй бөгөөд түүнийг нээж нийтэд зарлана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн
---------------------------	--

оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТУХАЙ” дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана. Хэрэв тендер солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулаххүсэлтийг уг тендерийг ирүүлсэн оролцогчийг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан болохыг баталгаажуулж, хүсэлтийн хамт ирүүлээгүй бол тендерийг солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй бөгөөд урьд ирүүлсэн тендерийг дангаар нь нийтийн өмнө нээж зарлана.

27.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, хэрэв захиалагч шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

27.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна.

- (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ солисон эсэх;
- (б) тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт (зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ), шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
- (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлснээс бусад тендерээс тендерийн нээлтийн үед татгалзахыг хориглоно.

28. Нууцлал

28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

29. Тендерийг тодруулах

29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тодруулга авахдаа зөвхөн албан бичгээр харилцана. Гэхдээ ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад

тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараах шаардлагыг хангаж буй эсэхийг нягтлана. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасанэсэх;
 - (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсанэсэх;
 - (в) шаардагдах баталгааг зөвшөөрөгдсөн маягтаар ирүүлсэнэсэх;
 - (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэнэсэх;
 - (д) тендерт оролцогч ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасанэсэх;
 - (е) ажил гүйцэтгэхэд тавигдах бусад шаардлагыг хангасан эсэх.
- 30.2. ТОӨЗ-ны 30.1 дэх хэсгийн (а)-(е) дэх заалтыг хангаж буй тохиолдолд тухайн тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 30.3. Шаардлагад нийцсэн тендер нь тендерийн баримт бичигт тавигдсан нөхцөл шаардлага, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн болон гэрээ хэрэгжүүлэх чадвар, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг материаллаг зөрүүгүйгээр хангасантендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ:
- (а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
 - (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
 - (в) тендерийн баримт бичигт шаардсаны зөрүүтэйгээр санал болгосон тендерийн саналыг хүлээн зөвшөөрөх, түүнийг засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.
- 30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

31. Алдааг залруулах

- 31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;

- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үргүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 31.2. Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.
- 32. Нэг валютад хөрвүүлэх**
- 32.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд зааснаас өөр валютараар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.
- 33. Дотоодын давуу эрх**
- 33.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт давуу эрхийн зөрүү тооцохгүй.
- 34. Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 34.1. Захиалагч зөвхөн ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хянан үзээд шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерүүдийг үнэлж, харьцуулна.
- 34.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ ТОӨЗ-ны 25 дугаар зүйлийн дагуу зарлагдсан тендерийн үнэд дараах байдлаар залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 31.1 –дзаасны дагуу алдааг залруулах;
 - (б) үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь дахь магадлашгүй ажлын зардлын дүнг хасах. Харин захиалагчийн шаардсаны дагуу тендерт оролцогчийн санал болгосон ажил-өдрийн зардлыг хасахгүй;
 - (в) ТОӨЗ-ны 27.4-д заасны дагуу зарлагдсан тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тооцож, тусгах;
 - (г) Дээрх буюу энэ зүйлийн (а), (б) болон (в) заалтын дагуу хийсэн залруулга, нэмэлт өөрчлөлт, үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн нийт үнийг ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд заасан үндсэн валют руу 32 дугаар зүйлд заасны дагуу хөрвүүлэх;
 - (д) Захиалагч материаллаг бус зөрүүтэй буюу бага хэмжээний зөрүүтэй гэж үзсэн тохиолдолд орхигдуулсан зүйлийн тоо

хэмжээний дутагдал, эсвэл илүүдлийн зөрүүг мөнгөөр илэрхийлэн тооцоолж, тендерийн үнэд тусгах;

- (е) Захиалагч зөвхөн 34.4-т тодорхойлсон үнэлгээнд харгалзах хүчин зүйлүүдийг тэдгээрт холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;
- (ё) ТОӨЗ-ны 33.1-д тусгайлан заасан бол дотоодын давуу эрхийн зөрүү тооцох.

34.3. Захиалагч нь аливаа өөрчлөлт, зөрүү болон хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Тендерийн баримтбичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар тендерийн баримтбичгийн шаардлагад заагаагүй ашиг тусыг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зөрүү, хувилбарт тендер болон бусад хүчин зүйлийг захиалагч тендерийг үнэлэхэд харгалзахгүй.

34.4. ТШӨХ-д тусгайлан заагаагүй бол захиалагч үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзахгүй:

- (а) *Гэрээний болон арилжааны зөрүү:*

Гэрээний болон худалдааны нэхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өртийг тооцоолж үнэлгээнд харгалзана.

- (б) *Ажлын гүйцэтгэлийн хугацаа:*

Энэ тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажлыг техникийн тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагуу болон түүнд багтааж дуусгах шаардлагатай тендерт оролцгчийн үнэ тус хуваарьт үндэслэсэн байх шаардлагатай. Тус хуваарьт зааснаас өмнө дуусгавар болгохыг санал болгосон тендерт урамшуулал олгохгүй. Тус хуваарьт зааснаас хоцорч ажлыг гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан хувийг⁴ тендерийн үнэ дээр нэмнэ. Ажлын гүйцэтгэлийн хуваарьт зааснаас ТШӨХ-д зааснаас⁵ илүү сар хоцроож дуусгахыг санал болгосон тендерээс татгалзана.

- (в) *Төлбөрийн хуваарийн зөрүү:*

Гэрээний тусгай нэхцөлд дурдсан төлбөрийн хуваариас өөр хуваарь санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор төлбөрийн хуваарьт зааснаас өмнөтөлөгдөх дунд сарын ТШӨХ-д заасан хувь⁶-тай тэнцэххүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

34.5. Хэрэв тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажил нь ТОӨЗ-ын 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

⁴ Ихэвчлэн 0.05 хувь.

⁵ Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичнэ.

⁶ Энэ хүү нь тендер зарлах үеийн тендерийн валютын арилжааны зээлийн зонхилох хүү байна.

- (а) багц тус бүрт ТОӨЗ-ны 34.1-34.3-т заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;
- (б) хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;
- (в) дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх бацгад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;
- (г) нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадлах. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.
- 34.6. Шаардлагад нийцсэн тендерүүдийг ТОӨЗ-ны 34.2, 34.3 болон 34.5-дзаасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна. Хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.
- 35. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 35.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлоходо ТОӨЗ-ны 5.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 5.3-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТОӨЗ-ны 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 35.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалzan сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.
- 36. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах**
- 36.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

-
- 37. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 37.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.6-д заасны дагуу хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 37.2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалаг түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 38. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 38.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 38.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 6 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.
- 38.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.
- 38.4. Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараах мэдээллийн хамтаар нийтлэнэ:
- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) Тендерт шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон үнэ, түүнчлэн батлагдсан гэрээний дүн.
- 38.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар

- тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.
- 38.6. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ын 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, гэрээнд гарын үсэг зурсны дараагаар захиалагч ТОӨЗ-ын 21.8-д заасан хугацаанд тендерийн баталгааг цуцлах талаар бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.
- 39. Гэрээнд гарын үсэг зурах**
- 39.1. Захиалагч нь гэрээний маяг болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 39.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 6-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
- 39.3. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 40. Гүйцэтгэлийн баталгаа**
- 40.1. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.
- 40.2. Гүйцэтгэлийн баталгааг:
- (а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар,
- эсхүл
- (б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.
- 40.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 40.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох, тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

**[ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР] ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Тендер шалгаруулалт/ Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга
гэрээний нэр: /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/
Дугаар: НХОГ2020-А/808-1

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТОӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвэл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ	A. Ерөнхий зүйл
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: [Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар]
ТОӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Багасургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/ НХОГ2020-A/808-1
ТОӨЗ 1.2	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: 2020 оны 08 сарын 01 өдөр
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв Төсөөвт өртөг: 1,506,500,000 /Нэг тэрбум таван зуун зургаан сая таван зуун мянган / төгрөг. 2020 онд санхүүжилт.
ТОӨЗ 4.2.2	Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.
ТОӨЗ 4.2.4	1. Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт, 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, 3. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ. Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

ТОӨЗ 4.4 (а)	Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.
ТОӨЗ 4.4 (б)	Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг Маягт №ТШМ 2-2 маягтын дагуу гаргаж ирүүлнэ.

<p>ТОӨЗ 4.4 (в)</p>	<p>Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай :</p> <p>Барилга, Хот байгуулалтын яамнаас олгогддог</p> <p>Хуучин: 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт</p> <p>2.1.2. Цутагмал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчилэлтийн ажил/1-5 давхар хүртэл/.</p> <p>2.1.4. Цутагмал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын ажил/1-16 давхар хүртэл/ Цамхаг тулгуур түшиц хана, яндан антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил</p> <p>2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</p> <p>2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо тохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиололын системын угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт</p> <p>2.2.3. Ариутгах татуургын гол / магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p> <p>2.2.4. Дулаан болон усан хангамжийн гол / магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p> <p>Шинэ: БА-4.1. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p> <p>БА-4.3. Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт</p> <p>БА-4.4. Дулааны гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног тахаарамжийн угсралт</p> <p>БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</p> <p>БА-6.2. Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</p> <p>БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлгийн, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт</p> <p>БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиололын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт</p>
----------------------------	---

	<p>БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтүн ажил</p> <p>Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчинтэй байх ба тусгай зөвшөөрлийн хүчинтэй нь дээр дурьдсан хугацааг хангаагүй буюу хүчингүй болсон зөвшөөрөл бүхий тендерээс татгалзана.</p>
ТОӨЗ 5.1	<ol style="list-style-type: none"> 1. Зураг төсөл болон ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлалыг ирүүлнэ. 2. Ажлын талбайтай танилцсан тухай тэмдэглэл, фото зургийн хамт баталгаажуулан ирүүлнэ.
ТОӨЗ 5.2 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018-2019 оны аудитын дүгнэлтийг ирүүлэх.

ТОӨЗ 5.2 (в)	Дараах хүснэгтэд үзүүлсэн голлох болон инженер техникийн ажилтныг ажиллуулна.				
	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил
	1	Ерөнхий инженер	1	5 болон түүнээс дээш жил	Барилгын инженер
	2	Барилгын инженер	1	5 болон түүнээс дээш жил	Барилгын инженер
	3	Цахилгааны инженер	1	3 болон түүнээс дээш	Барилгын инженер
	4	Ус хангамж, ариутгах татуургын инженер	1	3 болон түүнээс дээш	Ус хангамж, ариутгах татуургын инженер /Сантехникийн инженер
	5	Халаалт, агаар сэлгэлтийн инженер	1	3 болон түүнээс дээш	Халаалт, агаар сэлгэлтийн инженер
	6	Холбоо дохиолол, мэдээллийн технологийн инженер	1	3 болон түүнээс дээш	Холбооны инженер/
	7	Дулааны инженер	1	3 болон түүнээс дээш	Дулааны инженер
	8	Талбайн инженер	1	5 болон түүнээс дээш	Тухайн салбарын инженер
	9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	Тухайн салбарын инженер
<ul style="list-style-type: none"> - Инженер техникийн ажилчдын жагсаалтыг хүснэгтийн дагуу бөглөж ирүүлнэ. - Дээрх инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхний хуулбарыг ирүүлнэ. - Тухайн инженер, техникийн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулахын тулд нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, шаардагдсан жил тус бүрээр нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлнэ. - Ерөнхий инженер, барилгын инженер, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх ба нийгмийн даатгалын хэлтсээс баталгаажуулсан НД-8 маягтыг сүүлийн 3 сар /2020 оны 03, 04, 05 дугаар сар/-ын байдлаар хавсарган ирүүлнэ. 					

	Гэрээт ажилтан бол: Хөлсөөр ажиллуулах гэрээ болон сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхний хуулбарыг ирүүлнэ.
ТОӨЗ 5.2 (д)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018-2019 онуудад хийж гүйцэтгэсэн ажлыг нотлох баримт буюу ажил гүйцэтгэх гэрээ, улсын комиссын актын хуулбар, захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ./Шаардсан тусгай зөвшөөрлийн дагуу хийгдсэн ажлыг тооцож үнэлнэ/.

ТОӨЗ 5.2 (е)	<p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр</th><th>X/Н</th><th>Тоо ширхэг</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Автокран 10 тн-оос доошгүй 1</td><td>ш</td><td>1</td></tr> <tr> <td>2</td><td>Эксковатор 0.5м3-с дээш 1</td><td>ш</td><td>1</td></tr> <tr> <td>3</td><td>Ковш 90-140 м.х 1</td><td>ш</td><td>1</td></tr> <tr> <td>4</td><td>Авто ачигч</td><td>Ш</td><td>1</td></tr> </tbody> </table> <p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг хүснэгтийн дагуу бөглөж ирүүлнэ. Байгууллагын өөрийн эзэмшлийн машин механизм, багаж хэрэгсэл нь тухайн байгууллагын нэр дээр байх ба фото зураг гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээг эх хувиар хавсаргана. Мөн дээрх тоног төхөөрөмжүүдийг фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. Нийт машин механизмын 50 хувиас доошгүй нь өөрийн эзэмшлийн байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг тод гаргацтай хуулбарлан ирүүлнэ. /Тод гаргацгүй ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>	№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	X/Н	Тоо ширхэг	1	Автокран 10 тн-оос доошгүй 1	ш	1	2	Эксковатор 0.5м3-с дээш 1	ш	1	3	Ковш 90-140 м.х 1	ш	1	4	Авто ачигч	Ш	1
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	X/Н	Тоо ширхэг																		
1	Автокран 10 тн-оос доошгүй 1	ш	1																		
2	Эксковатор 0.5м3-с дээш 1	ш	1																		
3	Ковш 90-140 м.х 1	ш	1																		
4	Авто ачигч	Ш	1																		
ТОӨЗ 5.3 (а)	Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2018-2019 оны дундаж борлуулалтын хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 60% байна.																				

ТОӨЗ 5.3 (б)	Дуусаагүй ажлын явц нь 70-аас дээш хувийн гүйцэтгэлтэй, сүүлийн 3 жилд хамаарах барилга угсралтын ажлыг ижил төстэй ажилд тооцно. Тухайн 70-аас дээш хувийн гүйцэтгэлтэй барилга угсралтын ажлын гэрээ, ажлын явцын талаарх захиалагчийн тодорхойлолт, барилга угсралтын ажлын явцыг баталгаажуулсан фото зургуудыг ирүүлэх шаардлагатай.
ТОӨЗ 5.3 (д)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 60% -иас багагүй байна. <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны тодорхойлолтыг тендер нээхээс өмнө авсан байна./ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/.
Б. Тендерийн баримт бичиг	

ТОӨЗ 10.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.
В. Тендер бэлтгэх	
ТОӨЗ 13.1	Тендерийн хэл Монгол хэл байна.
ТОӨЗ 14.1 (а)	Тендерийн үнийн маягтыг тендерийн баримт бичигт заасан МАЯГТ No:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж ирүүлнэ. Анхааруулга: Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 3.3.2-т заасны дагуу илгээсэн тендерийн материалын агуулга нь системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл системийн талбарт бөглөсөн мэдээллийг баримтална.
ТОӨЗ 14.1 (б)	Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.

ТӨӨЗ 14.1 (ж)	<ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд: - Зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 13-ны 18 тоот, 2012 оны 181 дүгээр тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцно. - Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. - Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүнг төсөвт тусгаж ирүүлнэ. - Магадлашгүй ажлын зардал, норм нормативийн сангийн зардлыг төсөв зохиох зааврын дагуу, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлнэ. - Ажлын талбайн зохион байгуулалтын зураг гаргаж баталгаажуулан ирүүлнэ. - Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдлийг албан бичгээр ирүүлнэ. - Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ. - Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. - Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. - Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. - Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, өөрийн ирүүлсэн төсвийн дүнтэй арифметик алдаанаас бусад тохиолдоор зөрсөн, эсвэл үнийн хөнгөлөлт үзүүлж буй тохиолдолд үндэслэл шалтгааныг дурдсан мэдэгдлийг шаардлагатай нотлох баримтын хамт баталгаажуулан ирүүлнэ. /Ирүүлээгүй нь татгалзах үндэслэл болно. - Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно. - Нийслэлийн Хотыг стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас гаргасан:
--------------------------------	---

	<ul style="list-style-type: none"> - Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага /UCS0001-02:2019/, - Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага /UCS0002-02:2019/, - Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлагыг /UCS0001-02:2019/, тус тус зураг, төсвийг боловсруулахдаа тооцож ирүүлэх тухай албан мэдүүлэг ирүүлэх. - Тус газрын сайтаас үнэ төлбөргүй татаж авах боломжтой
ТОӨЗ 16.1	Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.
ТОӨЗ 17.8	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна .
ТОӨЗ 18.1	Тендерийн валют: Төгрөг байна .
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

ТОӨЗ 21	<p>Тендерийн баталгааны үнийн дүн: 22,642,500,00 мянган төгрөг /Хоин хоёр зургаан зуун дөчин хоёр мянга таван зуун төгрөг . Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал.</p> <p>Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргана.</p> <p>Анхааруулга: Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан гаргасан цахим тендерийн баталгааны мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах, нягтлах үүрэгтэйг анхаарна уу.</p>
Г. Тендер ирүүлэх	
ТОӨЗ 23.3 (6)	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдөр</p> <p>16 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p>

Д. Тендерийг нээх, үнэлэх

ТОӨЗ 24.1	<p>Төндерийн нээлт хийх газар, хугацаа:</p> <p>Байшин, гудамжны нэр Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Ц.Жигжиджавын гудамж, Бодь цамхаг 5 давхар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот.</p> <p>Аймаг, хот: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.</p> <p>Улс: Монгол Улс.</p> <p>Төндерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдөр.</p> <p>16 цаг 30 минут.</p>
ТОӨЗ 33.1	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: тооцно</p> <ul style="list-style-type: none"> Давуу эрхийг тооцохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан Давуу эрх олгох аргачлалыг тус тус баримтлана. <p>Төндөрт оролцогч нь дотоодын давуу эрх тооцуулах тохиолдолд албан хүсэлт, нотлох баримт ирүүлэх бөгөөд ирүүлээгүй бол давуу эрх тооцохгүй.</p>
ТОӨЗ 40.1	<p>Гэрээний маягтууд буюу VII бүлэг дэх тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгө дүн нь гэрээний үнийн дунгийн 5 хувьтай тэнцүү байна.</p>

МАЯГТ № ТШМ 2-2

ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____
компанийн _____ ажилтай
_____ овогтой _____ нь _____ компанийн
нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн
тул _____ ын дор зурсан гарын үсгийг
баталгаажуулж байна.

_____ нь _____ компанийг
төлөөлж _____ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл
байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг
баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг
зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 20__ оны __ дугаар сарын __-ны өдөр гарын үсэг
зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн

Овог, нэр _____

Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн

Овог, нэр _____

Гарын үсэг _____

МАЯГТ № ТШМ 2-3

**АЙМАГ, ХОТЫН
БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД
1	Оноосон нэр
2	Улсын бүртгэлийн дугаар
3	Гэрчилгээний дугаар
4	Тусгай зөвшөөрлийн дугаар
5	Өмчийн хэлбэр
6	Оршиж буй газрын хаяг
7	Шуудангийн хайрцаг, харилцах утас, факс, телексийн дугаар
8	Эрхэлдэг ажлын үндсэн чиглэл
9	Харьяалагдах татварын албаны нэр
10	Үйлчлүүлэгч банкны нэр, хаяг болон утас, факсын дугаар, дансны дугаар /гэрчилгээний тэмдэглэл хийгдсэн байх/
11	Байгуулагдсан он

Тайлбар: Хүчин төгөлдөр аж ахуйн нэгжийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл зэргийг нотариатаар баталгаажуулж хувийг хавсаргана.

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ _____
ОВОГ НЭР _____
КОМПАНИЙН НЭР _____

МАЯГТ № ТШМ 2-4

**ЕРӨНХИЙ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР СҮҮЛИЙН 2 ЖИЛД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ТӨРӨЛ БОЛОН ХЭМЖЭЭГЭЭРЭЭ ИЖИЛ ТӨСТЭЙ
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ БА ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮН**

№	Барилга угсралтын ажлын, хүч чадал, байршил	Захиалагч, Гүйцэтгэгчийн нэр, холбоо барих ажилтан	Гүйцэтгэсэн ажлын төрөл, дууссан он	Гэрээний үнэ (сая.төг)
1				
2				
3				

Тайлбар: Сүүлийн 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ижил төстэй барилга угсралтын ажлын гэрээний биелэлтийн талаарх захиалагчийн техник хяналт хийсэн хуулийн этгээдээс өгсөн тодорхойлолтыг хавсаргана.

Дуусаагүй гэрээний хэрэгжилтийн хувьд тайлбар хийсэн байна.

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ _____
ОВОГ НЭР _____
КОМПАНИЙН НЭР _____

МАЯГТ № ТШМ 2-6

**ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ХҮЧ ЧАДАЛ
(ТӨСЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД АШИГЛАХ МАШИН МЕХАНИЗМ
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ)**

Д/д	Машин механизм, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн нэр, марк	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа /жилээр/	Хүчин чадал, тоо ширхэг	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), хэдэн оноос ашиглаж байгаа	Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах
	А. Үндсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл				
1					
2					
3					
4					
	Б. Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл				
1					
2					
3					

Тайлбар: Зөвхөн тухайн төслийг хэрэгжүүлэх ажлын талбай дээр байнга ажиллах тоног төхөөрөмж, машин механизм, ажлын багаж хэрэгслүүдийн тодорхойлолтыг бичнэ.

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ _____
 ОВОГ НЭР _____
 КОМПАНИЙН НЭР _____

МАЯГТ № ТШМ 2-7

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛТАН, АЖИЛЧДЫН ЧАДВАР, ТУРШЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

Тайлбар: Гэрээнд санал болгож буй удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг хавсаргана.

ГАРЫН ҮСЭГ

ОВОГ НЭР

КОМПАНИЙН НЭР

МАЯГТ № ТШМ 2-8

**ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛБАЙ
ДЭЭРХИ НЭГЖИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Тайлбар: Зөвхөн тухайн төслийг хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, зохион байгуулалтын бүдүүвчийг үзүүлнэ.

Тэмдэг ГАРЫН ҮСЭГ _____
 ОВОГ НЭР _____
 КОМПАНИЙН НЭР _____

МАЯГТ № ТШМ 2-9

АЖИЛЛАХ ХҮЧ

(Төслийн ажлыг гүйцэтгэх гол мэргэжилтнүүдийн тодорхойлолт)

1. Овог нэр:
2. Нас:
3. Боловсрол:
4. Мэргэжил:
5. Мэргэжлээрээ ажилласан жил:
6. Төсөлд гүйцэтгэх үүрэг:
7. Төсөлтэй холбоотой ажлын туршлага:

Тайлбар: Энэ тодорхойлолтод төслийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчид хамрагдана.

Тэмдэг ГАРЫН ҮСЭГ _____
 ОВОГ НЭР _____
 КОМПАНИЙН НЭР _____

МАЯГТ № ТШМ 2-14

**БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ
ХУГАЦААНЫ ГРАФИК**

Тайлбар: Төсөлд тусгагдсан барилга угсралтын ажлыг үндсэн нэр төрлөөр гүйцэтгэх, зүгшрүүлэлт, туршилт тохируулга хийх, техникийн, ажлын болон улсын комисс ажиллуулан байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх зэрэг бүх ажлууд графикт тусгагдана.

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ

ОВОГ НЭР

КОМПАНИЙН НЭР

МАЯГТ № ТШМ 2-15

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ОДООГИЙН БА СҮУЛИЙН 2 ЖИЛИЙН
ХУГАЦААНД АЛИВАА ШҮҮХИЙН ЗАРГА, МАРГААНЫ ТАЛУУД
НЭХЭМЖЛЭЛИЙН МӨНГӨН ДҮН, ШИЙДЭГДСЭН БАЙДАЛ**

Нөгөө тал /үуд/	Маргааны шалтгаан	Нэхэмжлэлийн мөнгөн дүн	Шийдэгдсэн байдал
A)			
Б)			

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ

ОВОГ НЭР

КОМПАНИЙН НЭР

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

- 55.0** Ашиглалт, засвар үйлчилгээний хуваарь: *Гэрээнд гарын үсэг зурсанаас хойш 14 хоногийн дотор ажлын хуваарь гаргаж батлуулна.*
- 8.0** Бусад гүйцэтгэгчдийн хуваарь
- 9.0** Голлох мэргэжилтний хуваарь
- 14.0** Ажлын талбайн судалгааны тайлан
- 1.1** Захиалагч: *[Захиалагч байгууллагыг нөхөж бичнэ.]*
- 1.1** Төслийн менежер: *[Захиалагч байгууллагын тус төслийг хариуцсан эрх бүхий ажилтныг нөхөж бичнэ.]*
- 1.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: *[Гэрээний нэр, дугаар нөхөж бичих]*
- 1.1** Ажил нь: *[Төсөл, арга хэмжээний нэрийг нөхөж бичих]* болон түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал-аас бүрдэнэ.
- 1.1** Ажил эхлэх өдөр *[Захиалагчаас тодруулсны үндсэн дээр бичнэ.]*
- 1.1** Ажлын талбай нь *[Ажлын зургийн нэрийг нөхөж бичнэ.]*-д байрших ба зураг №03/17-д зааснаар тодорхойлогдсон болно.
- 3.0** Гэрээний баримт бичгүүд нь **Монгол хэл** дээр байна.
- 3.0** Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
- 13.0** Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:
Гүйцэтгэгч өөрөө хариуцна.
- 17.0** Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр нь *[Захиалагчаас тодруулсны үндсэн дээр бичнэ.]* өдөр байна.
- 21.0** Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр *[Захиалагчаас тодруулсны үндсэн дээр бичнэ.]*
- 25.0** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш **10** хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 25.0** Ажлын хөтөлбөрийг **14** хоног тутам тодотгоно.
- 25.0** Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь **байна**.

- 32.0** Чанарын баталгаат хугацаа **Ашиглалтад хүлээлгэж өгснөөс хойш ** жил байна.**
- 40.0** Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш **хоног байна.
- 45.0** Барьцаа хөрөнгийн хувь нь **5 хувь** байна.
- 46.0** Алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0,5 хувь** байна.
- 46.0** Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **50 хувь** байна.
- 49.0** Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн **5 хувь**-тай тэнцүү дүнтэй байна.
- Гүйцэтгэлийн баталгаа нь төндөрийн баримт бичгийн 7дугаар бүлэгт заасан маягтын дагуу байна.
- 52.0** Комисс ажиллах үед дутуу ажлууд илэрч уг объектийг комиссоор авах боломжгүй болсон тохиолдолд гүйцэтгэгч дутуу ажлаа дахин бүрэн дуусгаж комисс ажиллуулах мэдэгдлээ төслийн менежерт дахин гаргасан тэр хугацааг мөн ажил бүрэн дууссан хугацаа гэж тооцно. Гүйцэтгэгч гадна тохижолтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 55.0** Гүйцэтгэгч нь тухайн объектийг комиссоор хүлээн авсны дараа улсын комиссын актад дурдагдсан хугацаанд багтааж гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт, комиссын акт, протокол болон бусад холбогдох баримт материалуудаас бүрдсэн техникийн болон санхүүгийн хувийн хэргийг иж бүрэн бүрдүүлж Монгол хэл дээр 4 хувь үйлдэж төслийн менежер, ашиглагч болон архивын байгууллагуудын бүртгэлд ажил дууссан тухай мэдэгдэн албан ёсоор шилжүүлэх ажлыг хариуцан хийнэ.
- 55.2** Дээрх материалыг Улсын комиссын актаар хүлээлгэж өгснөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ нь: “тухайн материалыг бэлтгэхэд гарах зардлын хэмжээтэй тэнцүү” байна.
- 56.0** Гэрээ байгуулагдаж ажлын талбайг ашиглуулж эхэлснээс хойш 14 хоногт гүйцэтгэгч тухайн тендерт санал болгосон машин механизм, тоног төхөөрөмж, инженер техникийн ажилтнуудыг ажлын талбайд байршуулаагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах эрхтэй.
- 52.0** Комисс ажиллах үед дутуу ажлууд илэрч уг объектийг комиссоор авах боломжгүй болсон тохиолдолд гүйцэтгэгч дутуу ажлаа дахин бүрэн дуусгаж комисс ажиллуулах мэдэгдлээ төслийн менежерт дахин гаргасан тэр хугацааг мөн ажил бүрэн дууссан хугацаа гэж тооцно. Гүйцэтгэгч гадна тохижолтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2020** оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **[Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/]**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХХОГ2020-А/808-1**

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас эрх бүхий тендерт оролцогдоос **[Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/]** гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 **хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: **Багцгүй.**

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн **2** жил буюу **2018, 2019**, онуудын дундаж/аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн **[60 хувь байхаар]** хувиас багагүй байна.

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендерт санал болгож буй үнийн дүнгийн **[60 хувь байхаар]** хувиас багагүй байх.

3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу **2018, 2019**, онуудын жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/-ын хуулбарыг ирүүлнэ.

4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн **2** жил буюу **2018, 2019**, онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн **[60 хувь байхаар]** хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд **Тусгай зөвшөөрлийн хүрээнд** гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

Барилга, Хот байгуулалтын яамнаас олгогддог:

Хуучин: 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчилэлтийн ажил/1-5 давхар хүртэл/.

2.1.4. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын ажил/1-16 давхар хүртэл/ Цамхаг тулгуур түшиц хана, яндан антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил

2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

2.2.2.Барилгын дотор гэрэлтуулэг, цахилгаан хангамж, холбоо тохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиололын системын угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

2.2.3. Ариутгах татуургын гол / магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

2.2.4.Дулаан болон усан хангамжийн гол / магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Шинэ: БА-4.1.Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

БА-4.3. Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт

БА-4.4. Дулааны гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног тахаарамжийн угсралт

БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.2. Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтуулгийн, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол,интернет сүлжэ, гал унтраах болон галын аюулын дохиололын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчинтэй байх ба тусгай зөвшөөрлийн хүчинтэй нь дээр дурьдсан хугацааг хангаагүй буюу хүчингүй болсон зөвшөөрөл бүхий тендерээс татгалзана.

- Шаардагдах тусгай зөвшөөрлийг нөхөж бичих /нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ/

Тендерийн хамт **1,5 хувь байхаар 22,642,500,00 мянган төгрөг /Хорин хоёр зургаан зуун дөчин хоёр мянга таван зуун төгрөг**

Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал.

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 16 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба тендерийг **2020 оны 07 дугаар сарын 16 -ны өдрийн 16 цаг 15 минутад** Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Бодь цамхаг, 5 давхар, 503 тоот, нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх **тооцно**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Бодь цамхаг, 5 давхар, 503 тоот, Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар, Утас: 310066.